



**АРХАНГАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА...../Д.ДЭЛГЭРСАЙХАН/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....
(огноо)

Төлөвлөгөөг тайлагнасан:

Төсвийн Шууд захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА...../Г.ГАЛСАНДОРЖ/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....
(огноо)

АРХАНГАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурьтвшин	Зорилт түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн Хувь
ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.							
/“Алсын хараа-2050” зорилт 5.3, 7.4, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, 7.4, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө, Архангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 4.1.3 /							
Зорилт1.Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.							
1.1	Тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах	-	-Тоон гарын үсэг олгох бэлтгэл ажлыг хангасан эсэх; -Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо; -Иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо.	20	50	Тоон гарын үсэг олгох бэлтгэл ажлыг бүрэн хангаж, тоон гарын үсэг олгох программ, техник үйл ажиллагааны сургалтанд онлайнаар 20 албан хаагч бүрэн хамрагдсан. Эхний хагас жилийн байдлаар 29381 иргэнд тоон гарын үсэг олгосон нь нийт олгох хүн амын 46,6%-д олгоод байна.	90
1.2	Иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлж, шинэчилсэн загвар бүхий үнэмлэхийг олгох	-	Шинэчилсэн загвараар иргэний үнэмлэх олгосон тоо	2	20	2022.12.13-ны өдрөөс эхлэн хэвлэгдэн ирсэн иргэний бүртгэлийн дугаартай 1384 иргэний үнэмлэхийг иргэдэд олгож ажилласан байна.	100
1.3	Цахим гадаад	-	Цахим гадаад паспортыг	0	10	2023 оны 01 дүгээр сараас эхлэн	100

	паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх		олгох бэлтгэл ажлыг хангасан эсэх; -Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо;			ИУБГ, МТГ-аас хийсэн 6 удаагийн программын болон эрх зүйн цахим сургалтад гадаад паспортын бүртгэл хариуцсан бүртгэгч, иргэний улсын ахлах бүртгэгч нар оролцож, цахим гадаад паспортын зураг авах буланг тохижуулан, бэлтгэл ажлыг ханган ажилласан. 2023.03.01-ний өдрөөс эхлэн 157 иргэнд цахим гадаад паспортыг олгохоор захиалга хүлээн авсанаас, 149 иргэнд 10 жилийн хугацаагаар гадаад паспортыг хэвлүүлэн олгосон. 8 цахим гадаад паспорт хэвлэгдэх шатандаа явж байна.	
1.4	Цахим төлбөрийн хэрэгсэл болох пос машины тоог нэмэгдүүлэх. Улсын бүртгэлийн цахим машин дахь үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	-	Пос машинаар үзүүлсэн үйлчилгээний тоо.	40	100	2 пос машинаар 1077 иргэн үйлчилгээний хураамж төлж 1.389.000 төгрөгийн орлогыг төсөвт оруулсан байна.	100
1.5	Шинэлэг ажил зохион байгуулж, ажлын үр дүнг тооцох.	-	Зохион байгуулсан шинэлэг ажлын тоо	70	100	Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хүрээнд Дотоод хяналт шалгалтын бүрэлдэхүүнийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан төлөвлөгөө батлуулан төлөвлөгөөний хүрээнд байгууллагад болон бүртгэлд үүсч болох эрслэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Аймаг байгуулагдсаны 100 жилийн ажлын хүрээнд Хэлтсийн	100

						<p>үйлчилгээний заалыг тохижуулах, үйлчлүүлэгчийн ая тухтай орчинг бий болгох талд анхаарч тохижилтийн ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэж мөн байгууллагын гадаад хаягийг шинэчлэн, гадаад орчны тохижилтыг сайжруулж өнгө үзэмжийг сайжруулж ажилчдын ажиллах таатай орчныг бий болголоо.</p> <p>Өрх толгойлсон Аавуудын сэтгэл санаа, амжиргааны түвшинд дэмжлэх үзүүлэхээр хэлтсийн зүгээс Эрдэнэбулган сумын 6 хүүхдэд хичээлийн хэрэгслээр дэмжлэг үзүүллээ.</p> <p>Бага насны болон нярай хүүхэдтэй эмэгтэйчүүдэд зориулан хүүхэд хуурайлах, хооллох хэсгийг үйлчилгээний зааланд тусгайлан бэлдэж тэднийг ая тухайтай үйлчилгээ авах боломж нөхцөлөөр ханган ажиллаж байна.</p> <p>Номын буланг нээж үйлчилгээ авч буй иргэн хүлээх зуур ном, сэтгүүлтэй танилцаж, мэдээлэл авч байна.</p> <p>Хэлтсийн үйлчилгээний зааланд угтах үйлчилгээг уламжлал болгон явуулж Киоск болон E Mongolia цахим системээр үйлчлүүлэх иргэдийн лавлагаа үйлчилгээ авах нөхцлийг сайжруулж бүртгэгчийн ажлын ачаалал буурсан давуу тал бий болж байна.</p>	
1.6	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг		-санал хүргүүлэн ажилласан эсэх	40	80	Архангай аймгийн АВ телевиз 4 удаагийн сурталчилгаа нэвтрүүлэг	

	боловсронгуй болгох байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм журам зааварт санал хүргүүлэх, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлах	-	-Сурталчилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрөл; -Олон нийтэд сурталчилсан мэдээ, мэдээллийн тоо;			хийж ажиллаа. Тус сурталчилгааны хүрээнд иргэдэд тоон гарын үсгийн олголт түүний ач холбогдол, улсын бүртгэлийн хэлтсийн хийж гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний талаар олон нийтэд мэдээлэл хүргэхэд голлон анхаарч мэдээлэл хүргэн ажилласан. Архангай аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн пэйж хуудсанд 74 удаагийн мэдээ, мэдээлэл https://arkhangai.burtgel.gov.mn/ вэйб сайтад иргэд аж ахуй нэгж, олон нийтэд чиглэсэн 45 мэдээ, мэдээллийг оруулсан үйл ажиллагаагаа ил тод байрлууллаа.	100
Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ							
2.1	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх.	-	-Улсын бүртгэлд бүртгэгдсэн бүртгэлийн тоо	100	100	2023 оны эхний хагас жилийн байдлаар төрсний 717 , үрчилсний 10 , овог, эцэг /эх/ийн нэр, нэр өөрчилсний 20 , эцэг /эх/ тогтоосны 13 , гэрлэсний 149 , гэрлэлт дуусгавар болсны 17 , нас барсны 236 , иргэний үнэмлэх олгосны 1269 , шилжилт хөдөлгөөний 490 , регистрийн дугаар өөрчлөлтийн 8 , биеийн давхцахгүй өгөгдлийн 1577 , гадаад паспорт олголтын 976 , гадаад паспортыг хүчингүй болгох 551 , иргэний үнэмлэх хүчингүй болгох 914 , тоон гарын үсэг олголтын 7900 , нийт 13382 ширхэг бүртгэл бүртгэгдсэн. E-mongolia цахим системээр 36 иргэн үндэсний энгийн гадаад паспорт, 128	100

						<p>иргэн иргэний үнэмлэх тус тус дахин захиалан авсан байна.</p> <p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр иргэн хуулийн этгээдээс нийт 2959 мэдүүлгийг хүлээн авч анхны бүртгэл 466 , өмчлөх эрх шилжих бүртгэл 577, барьцааны эрхийн бүртгэл 1722, бусад эрхийн бүртгэл 86 , лавлагаа хуулбар 106, хувин хэрэг бүртгэлийг хаах 14 хийж нийт улсын төсөвт үйлчилгээний хуураамжаар 27.648.085 төгрөг, тэмдэгтийн хураамжаар 2.685.369 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 93.150.297 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна. Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр нийт 384 бүртгэлийг хийсэн байна. хуулийн этгээд байгуулагдаж үүнд:</p> <p>Хязгаарлагдмал хариуцлагатай компани 49, Хоршоо 9, Төрийн бус байгууллага 10, Нөхөрлөл 2, салбар төлөөлөгчийн газар 1, мэдээлэлд оруулсан өөрчлөлт 116, шинэ оноосон нэрийн хүсэлт 73, татан буугдсан 0, дахин гэрчилгээ 5, хэлбэр өөрчилсөн 7, шилжилт хөдөлгөөн хиисэн 3 тус тус бүртгэлийн үйлчилгээг хууль, журманд нийцүүлэн, түргэн шуурхай үзүүлсэн.</p>	
2.2	Сумдад эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх	-	- Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй сумдын тоо;	20	40	<p>Хагас жилийн байдлаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг сумын төвөөс үзүүлэх эрх авсан Хангай сумын улсын бүртгэгч С.Алтантуяа нийт 58 мэдүүлгийг</p>	80

	ажлыг эхлүүлэх .		-Сумын улсын бүртгэгчийн хөтөлсөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоо.			хүлээн авч бүртгэлийг хийж иргэдэд түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Эрх зүйч мэргэжилтэй Батцэнгэл, Хашаат, Өгийнуур, сумын улсын бүртгэгч нар сургалтанд хамрагдан шалгалт өгч эрх авах хүсэлтээ УБЕГ-т санал хүргүүлсэн.	
2.3	Хаягжуулалтын журмын хүрээнд хаяг шинэчлэгдсэн иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ солих ажлыг зохион байгуулах.	-	Үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн нэмэлт өөрчлөлт хийсэн бүртгэлийн тоо.	40	60	Сумын засаг даргын тамгын газар, газрын даамал сумдын улсын бүртгэгч нартай хамтран Хотонт, Өндөрүлаан, Жаргалант, Ихтамир, суманд шинээр хаягжсан гудамж үл хөдлөх хөрөнгийн хаягийг шинэчлэх, гэрчилгээг солих арга хэмжээг зохион байгуулж ажиллан нийт 85 бүртгэлийг хийж гэрчилгээг олгон ажиллаа. ГХБХБГазартай хамтран 2022-2023 онд шинээр ашиглалтанд орсон нийт 5 орон сууцны гэрчилгээг шинэ хаягаар олгон ажиллаж байна. Мөн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр олгосон газар болон газраас бусад үл хөдлөх хөрөнгийн хаягийг кадастрын зураг болон эрх бүхий байгууллагын хаяг олгосон шийдвэрийг үндэслэн шинэ хаягаар бүртгэл хийж байна. Хаягжуулалтын журам, газрын мэдээллийн сангийн шинэчлэлтэй холбоотойгоор нийт 139 эд хөрөнгийн хаяг өөрчилсөн бүртгэлийг хийгээд байна.	100
2.4	Нотариатчтай “Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулах,	-	-“Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулсан Монголын нотариатчдын	0	10	Нотариатчтай “Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулах, дундын мэдээллийн	0

	дундын мэдээллийн сангаар дамжуулан мэдээлэл нийлүүлэх, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд нотариатч зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх.		танхимын гишүүн нотариатчдын тоо; - Нотариатын мэдээлэл шалгах системд нийлүүлсэн мэдээллийн тоо; -нотариатаар зуучлуулан эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн бүртгэлийн тоо.			сангаар дамжуулан мэдээлэл нийлүүлэх ажлууд УБЕГазар, ЭХЭУБГазрын хэмжээнд хийгдэж байгаа учраас программ нэвтэрч бүртгэл хийх хугацаа тодорхойгүй байна.	
2.5	Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар үзүүлэх системийг сурталчлах замаар хэрэглээг нэмэгдүүлэх.	-	-Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэл тоо -Барьцааны гэрээ дуусгавар болгосон бүртгэлийн тоо	0	100	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/427 дугаар тушаалаар батлагдсан барьцааны гэрээ, гэрээний өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт ЭУБ-06, ЭУБ-13 маягтаар бүртгэлийг хийж байна.	0
2.6	Хууль хяналтын байгууллагад цахим хэлбэрээр олгох улсын бүртгэлийн лавлагаа, хуулбар олгох үйл ажиллагааг зохион байгуулах, сурталчлах.	-	Хууль хяналтын байгууллагад цахимаар олгосон лавлагаа, хуулбарын тоо	0	10	Лавлагаа мэдээллийг цахимаар олгох ажил одоогийн байдлаар эхлээгүй бөгөөд бэлтгэл ажлууд болох мэдээллийн сангийн үнэн зөв зөрүүгүй байх бүртгэлийн зөрчлийг арилгах ажлууд шат дараатайгаар хийгдэж байна. Эхний хагас жилийн байдлаар нийт 3730 лавлагааг хүргүүлэн ажилласан байна.Үүнээс: Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр иргэд, байгууллагад 3555 лавлагааг гарган үйлчилсэн байна. Үйлчилгээний танхимаас: Иргэний үнэмлэхийн хуулбар - 518 лавлагааг бүртгэлийн хуулбар болон бусад бичиг баримтыг үндэслэн шүүх,	0

						цагдаа, прокурор зэрэг төрийн болон төрийн бусад байгууллагад албан тоотоор 423 иргэний үнэмлэхийн хуулбарыг, сумдын бүртгэгч нар албан хэрэгцээнд 358 , иргэдэд 1550 лавлагааг тус тус олгосон байна.Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 30 Хуулийн этгээдийн бүтгэлийн чиглэлээр 21 III-IV улиралд олгож эхлэхээр төлөвлөсөн.	
2.7	Аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэст хөтлөгдсөн иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах.	-	Цахимжуулсан иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтын тоо	100	100	2023 онд бүртгэсэн иргэний улсын бүх төрлийн бүртгэлийн 9081 ширхэг эх нотлох баримтуудыг, эцэг, эхийн мэдээлэл бүртгэгдээгүй, зөрүүтэй 421 хүүхдүүдийн ИУБ маягтуудыг, нийт 9502 эх нотлох баримтуудыг цахимжуулсан байна.	100
2.8	Улсын бүртгэлийн үйлчилгээнд дундын мэдээллийн сан ашиглах	-	-ЭМГ-тай төрөлтийн бүртгэлийн мэдээлэл солилцсон тоо	100	100	ЭМГ-аас төрсний 717 хүүхдийн СТ-4 маягт, нас барсны 237 иргэний АМ-7 маягтуудыг үндэслэн нийт 954 төрсний, нас барсны бүртгэл бүртгэсэн байна.	100
2.9	Тамга, тэмдэг хэрэглэх эрх бүхий этгээдээс хураалгасан тамга, тэмдгийг төрийн архивт шилжүүлэн хадгалуулах	-	-Төрийн архивт шилжүүлсэн тамга тэмдгийн тоо.	0	30	УБЕГ-ын даргын 2021 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн А/55 тушаалын хэрэгжилтийг хангаж өдөр тутмын бүртгэл хөтлөхдөө мөрдлөг болгон ажиллаж эхний хагас жилийн байдлаар нийт төрийн байгууллага болон бусад аж ахуй нэгжүүдээс 29 тамга, тэмдэг хуулийн дагуу хурааж үндэсний төв архив болон орон нутгийн төрийн архивт шилжүүлэхэд	100

						бэлэн болоод байна.	
2.1 0	Улсын бүртгэлийн мэдээллийн санд зөрчилтэй бүртгэлийн судалгаа гаргаж, зөрчлийг арилгах арга хэмжээ зохион байгуулах	-	-Улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулсан засвар өөрчлөлтийн тоо	50	100	Хагас жилийн байдлаар Хяналтын улсын байцаагчийн 1500, 1543 нэгдсэн дүгнэлтээр нийт 2221 бүртгэлийн зөрчлийг арилган мэдээллийн санд засаж бүртгэлийг үнэн зөв болгон ажиллаа. ЭХЭУБГазрын даргын 6/277, 5/1854, 5/3231, 5/4618 тоотоор ирүүлсэн нийт 703 хэрэг бүртгэлийг цахим санд цаасан нотлох баримттай тулган шалгаж зөрчилгүй 301 бүртгэл, 649 бүртгэлийг зөрчлийг бүрэн арилгасан. Нэгж талбарын дугаар оруулаагүй 54 бүртгэлийг шалгаж ГХБХБГазраас нэгж талбарын дугаарын талбарыг авч зөрчлийг арилгасан. 2023.01.19-нд МТГ-аас ирсэн 765 иргэний зургыг мэдээллийн санд нэг бүрчлэн нягтлан шалгаж, зөрчилгүй тухай илтгэх хуудсыг 2023.01.20-нд n.narantsetseg@burtgel.gov.mn хаягаар хүргүүлсэн. 2. 2023.01.23-нд ИУБГ-аас ирсэн нэг хаягт 10-аас дээш оршин суугчийн мэдээлэл бүртгэгдсэн 13 сумын 230 хаягийг нягтлан шалгаж, зөрчлийг 2-р улиралд багтаан арилгахыг бүртгэгч нарт үүрэг болгосон. 1-р улирлын байдлаар 6 сумын 11 хаягийн оршин суугчийн мэдээллийн зөрчлийг бүрэн арилгаад байна. Аймгийн төвийн сум болох Эрдэнэбулган суманд хамгийн их буюу 182 хаягт 10 дээш оршин суугч	85

						<p>бүртгэгдсэн байх тул ЗДТГ-т зөрчлийг хамтран арилгах тухай албан бичгийг хүргүүлэн зөрчлийг хамтран бүрэн арилгасан.</p> <p>3. 2008-2011 оны 8398 хүүхдийн төрсний ХААТР-11 маягтыг санд нэг бүрчлэн нягтлан шалгаж, 421 хүүхдийн мэдээлэлд засвар өөрчлөлтийн бүртгэл хийж, үг үсэг, эцэг эхийн мэдээллийг зөв болгон залруулсан. Ургийн овог зөрүүтэй, эцэг, эхийн мэдээлэл шивэгдээгүй 120 хүүхдийн бүртгэлийн алдааг нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр залруулхаар албан бичгийг ИУБГ-т хүргүүлсэн.</p> <p>4. 2023.04.26-нд ИУБГ-аас ирсэн цахим санд “бүртгэсэн” төлөвтэй төрөлтийн 31, гэрлэсний 1, гэрлэлт цуцласны 4, нийт 36 бүртгэлийг архивын цаасан баримттай тулгах, бүртгэл үнэн, зөв бол ард нь баталгаажуулах, буруу мэдээллээр бүртгэгдсэн, эсхүл давхар бүртгэгдсэн бол ХУБ-ын дүгнэлт гаргаж хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт орох гэсэн тэмдэглэгээг хийхээр нягтлан шалгаж байна.</p>	
2.1 1	Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох	-	-Хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны тоо; -Шүүх хуралдаанд оролцсон тоо;	100	100	Тус хэлтэст хамаарах Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хариуцагчаар татагдсан хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож 2023 оны 04 сарын 10 өдрийн шийдвэрээр хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.	100

2.1 2	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих.	-	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	100	100	Хагас жилийн байдлаар тус хэлтэст : Хариутай албан бичиг нийт-387 Шийдвэрлэгдсэн-385 Шийдвэрлэгдэж байгаа-2 Явсан бичиг нийт -474 Өргөдөл гомдол нийт-115 Шийдвэрлэгдсэн –111 Албан бичиг, өргөдөл , гомдлын тайлан мэдээг холбогдох газар хэлтэст хуулийн хугацаанд 5 удаа гарган хүргүүлсэн.	100
2.1 3	Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан, хүргүүлэх.	-	Хүргүүлсэн болон тайлагнасан мэдээ, тайлангийн тоо	100	100	Сар бүрийн 25- нд бүртгэлийн тоон мэдээг ИУБГ,ЭХЭУБГ ХЭУБГазарт 5 удаа, үнэт цаасны тайланг хэлтсийн нягтлан бодоход 5 удаа, хувийн хэрэг архивын тоон мэдээг 5 удаа тус тус гарган холбогдох газар хэлтсүүдэд хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. Мөн Татварын хэлтэст холбогдох мэдээ тайланг тухай бүр нь хүргүүлэн ажиллаж байна.	100
2.1 4	Архивын хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангах.	-	Ажлын гүйцэтгэлийн хувь.	80	100	Эхний хагас жилийн байдлаар Иргэний улсын бүртгэлийн 126.744 , Эд хөрөнгийн эрхйн улсын бүртгэлийн 25.249 , хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн 2039 ширхэг хувийн хэрэг хадгалагдаж байна. Архивын эх нотлох баримтын хадгалалт хамгаалалтанд онцгойлон анхаарч цэгцлэх стандарт өрөө тасалгаанд байршуулах ажлыг хийж ирлээ. Шинээр нээгдсэн болон үйлчилгээ	100

					<p>орсон хувийн хэргийн баяжилтыг цаг тухай бүр нь хийж хадгаламжийн сан үүсгэн ажиллаж байна. Архивын фондоос 761 иргэний хувийн хэргийг шүүж, 34 иргэний зерчилтэй маягтыг нөхөн бүрдүүлэлтээр шивж, баталгаажуулан зөрчлийг арилгаж, сарын мэдээгээр ирсэн 7 терлийн бүртгэлийн 923 ширхэг, шилжилт хөдөлгөөний 414 ширхэг, харьяалал харгалзахгүй бүртгэл хийлгэсэн иргэдийн 759, албан тоотоор ирүүлсэн 148 иргэний хувийн хэргийн ХААТР, ИУБ маягтуудыг эмхэлж цэгцлэн, цагаан толгойн үсгийн дарааллаар галиглах ажлуудыг шат дараалан хийж, иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн 1273 иргэний ИУБ-31 маягтыг журмын дагуу галиглан нийт 3551 ширхэг ИУБ маягтын “А” талыг УБЕГ-т хүргүүлэн, “Б” талыг архивт байршуулсан.</p> <p>Өөр аймаг, нийслэл рүү харьяалал харгалзахгүй бүртгэл хийлгэсэн иргэдийн 195, албан тоотоор 1580, нийт 1775 иргэний хувийн хэргийн ХААТР, ИУБ маягтуудыг хүргүүлсэн.</p> <p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 537 ширхэг хувийн хэргийг цахим санд тулган шалгаж тусгаарлагдсан нийт 15038 хуудсыг хувийн хэргээс авч 250 хадгаламжийн нэгж үүсгэсэн. Тусгаарласан хуудсыг ЭХЭУБГазрын даргын 2022 оны 6/3763 тоот чиглэлийн дагуу усгалд оруулах</p>	
--	--	--	--	--	---	--

						арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	
2.1 5	Хуулийн этгээдийн болон Эд хөрөнгийн архивын санг зориулалтын нягтруулсан шүүгээгээр шинэчлэх		Шинээр суурьлуулсан шүүгээний тоо	0	5	Эд хөрөнгө , хуулийн этгээдийн архивт 19,7 сая төгрөгийн үнэ бүхий 12 ширхэг нягтруулсан шүүгээг худалдан авч байршуулахад бэлэн болсон.	100
2.1 6	Архивын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангах		-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо; -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	100	100	2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хэлтсийн даргаар Иргэний улсын бүртгэлийн болон Эд хөрөнгө, хуулийн этгээдийн архивын 8 заалт бүхий төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийн заалт бүрээр ажил зохион байгуулан ажиллаж байна.	90
2.1 7	Хэлтсийн үйлчилгээний танхимд байрлах “цахим хөтөч”-өөр бүртгэлийн үйлчилгээг e-mongolia ,E-business ээр үзүүлэх	-	-Цахим хөтөчөөр үзүүлсэн үйлчилгээний тоо; -Сэтгэл ханамжийн судалгааны дүн	657	150 0	Гар утсаараа үйлчилгээ авах боломжгүй иргэдэд үйлчилгээний танхимд зөөврийн компьютер байрлуулан “Цахим хөтөч” буланг байгуулан улсын бүртгэгч нар хуваарийн дагуу E-Mongolia цахим системийг 307 иргэдэд зааж өгч, зөвлөн туслах хэлбэрээр үйлчилгээ үзүүлж байна. E-mongolia системээр 108 иргэн иргэний үнэмлэх, 27 иргэн үндэсний энгийн гадаад паспорт тус тус дахин захиалан авсан байна. Мөн улсын бүртгэгч нар хуваарь гарган үйлчилгээний танхимд байрлах “КИОСК” машинаас үйлчилгээ авч буй	100

						109 иргэдэд лавлагаа болон тоон гарын үсэг авахад нь туслан, үйлчилж байна.	
2.1 8	Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааг сурталчилсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулах.	-	-“Нээлттэй хаалга”-ны өдөрлөгөөр зөвлөгөө авсан иргэний тоо; -Үзүүлсэн бүртгэлийн тоо	173 0	250 0	Хэлтсийн зүгээс эхний хагас жилийн байдлаар эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр Ихтамир, Хотонт, Жаргалант, Өндөрүлаан сумдад “НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ” зохион байгуулж нийт 700 гаруй иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч 592 бүртгэлийг хийж ажиллаа. 2022.05.01-ний өдрийн “Хуульчийн про боно өдөрлөг”-т эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний бүртгэл чиглэлээр гарын авлага бэлтгэн 355 иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудад хүргэн, бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилан ажиллаа. Улсын бүртэгч томилогдоогүй Ихтамир, Хотонт, Жаргалант суманд 2023.04.13-нд, 2023.06.05-нд өдрүүдэд “НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ” зохион байгуулж нийт төрсний 8, нас барсны 2, биеийн давхцахгүй өгөгдлийн 20, шилжилт хөдөлгөөний 4, нийт 34 бүртгэл хийж, 480 иргэнд тоон гарын үсэг, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 56 бүртгэлийг хийж гэрчилгээг олгон ажилласан. 18 сумын бүртгэгч нар сумын Засаг даргын Тамгын газар, нийгмийн даатгал, газрын харилцаа, татварын	100

						хэлтэс зэрэг байгууллагуудтай хамтран “Нээлтэй хаалга”-ны өдөрлөгийг “Нэг цонх”-ны үйлчилгээний зааландаа зохион байгуулан ажилласан байна.	
Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ .							
3.1	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх.	-	-Зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн тоо; -Зөрчлийг зөрчлийн хэрэг нээн шалган шийдвэрлэсэн тоо.	478	213	Хялбаршуулсан журмаар 213 иргэний ирүүлсэн гомдлыг хүлээн авч нийт 4.260.000 төгрөгийн торгууль оногдуулж шийдвэрлэсэн. Хуульд заасан хугацаанд прокурорт хянуулан зөрчилгүй, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд зөрчлийн хэрэг нээж шийдвэрлээгүй болно.	100
3.2	Хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжүүлж ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	80	100	Хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулан улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд иргэний улсын бүртгэлийн 564, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 65, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 200, архивын 100 бүртгэлд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт тавьж сар бүр тоон мэдээг Хяналт, шалгалтын газарт хүргүүлэн ажиллаж байна. Илэрсэн 71 зөрчлөөс 69 зөрчлийг тухай бүр нь арилгуулан ажиллаа. Чулуут, Өгийнуур сумын 1 улиралд бүртгэсэн бүртгэлийн үйл ажиллагаанд	80

						хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч цаашид зөрчилгүй ажиллах анхааруулга зөвлөмж хүргүүлж ажиллаа.	
3.3	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Шинээр томилогдсон албан хаагчдаас болон шаардлагатай тохиолдолд авсан нууцын баталгааны тоо	31	31	Нууцтай холбоотой үйл ажиллагааны тайланг 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын нууц хамгаалах ажилтанд хүргүүлсэн болно. 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр нийт албан хаагчдаас нууцын баталгааг шинэчлэн гаргуулж авсан. Шинээр томилогдсон албан хаагчдаас нууцын баталгааг томилогдсон даруйд нь гаргуулж авсан. Сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах албан хаагчаас нууцын баталгааг мөн гаргуулж авсан.	100
3.4	Ерөнхий газрын дарга, Даргын зөвлөлийн хурал, чиглэлийн газар, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаас гарсан үүрэг даалгаврыг хяналтад авч, хэрэгжилтийг хангах.	-	-Хяналтад авсан үүрэг даалгаврын тоо; -Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь;	100	100	Ерөнхий газраас өгсөн 4 үүрэг, даалгаврыг цаг хугацаанд хүлээн авч албан хаагчдад чиглэл бүрээр нь танилцууллаа. Мөн сумдын бүртгэгч нар хэлтсийн даргын албан тоотоор үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг тухай бүрт тооцон ажиллалаа. Газрын дарга болон чиглэлийн газраас өгсөн өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг цаг алдалгүй гүйцэтгэж хариу тайланг хугацаанд УБЕГ-т хүргүүлж ажиллалаа. Даргын зөвлөлийн хурал, чиглэлийн газруудаас ирүүлсэн 15 чиглэлийн хүрээнд албан хаагчдадаа шуурхай хуралдаан 18 зохион байгуулж,	100

						хэрэгжилтийг хангууллаа. Мөн сумдын бүртгэгч нартай цахим хурал 11 зохион байгуулж, үүрэг, чиглэл хүргүүлэн ажиллаа.	
3.5	Үндэсний аудитын газар болон бусад байгууллагаас ирүүлсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах.	-	Зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийн хувь	100	100	2022 оны санхүүгийн тайланд аудит хийлгэж “Зөрчилгүй дүгнэлт”, тайлангийн хамт Улсын бүртгэлийн ерөнхий газарт хугацаанд нь хүргүүлсэн. Зөвлөмж, акт байхгүй. 2023 оны 02 сарын 10 өдрийн 17/АО370216 тоот албан шаардлагын биелэлтийг 2023 оны 04 сарын 15 өдрийн№ 220 дугаар албан бичгээр шаардлагын биелэлтийг хүргүүлсэн.	100
3.6	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих.	-	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хувь.	100	100	Тус хэлтэс нь эхний хагас жилийн байдлаар нийт улсын төсөвт үйлчилгээний хураамжаар 59.424.000 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжаар 18.200.000 төгрөг үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны алба татвараар 93.150.297.000 төгрөгийг тус тус төвлөрүүлэн ажиллаж байна.2023 оны эхний хагас жилийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт нь 255801.2 мянган төгрөгийн төсөвлөгдсөн. Үүнээс 05 дугаар сарын 30 байдлаар 255078.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Санхүүгийн сар бүрийн мэдээ мэдээлэл, тайланг 5 удаа гарган https://shilendans.gov.mn/ , https://auth.itc.gov.mn/ , https://auth.itc.gov.mn/ , https://hrm.csc.gov.mn/hrsuite , https://nd8.ndaatgal.mn/ болон бусад	100

						программ, сайтуудад байршуулан ажиллаж байна.	
3.7	Улсын төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах.	Урсгал төсөв / 581.2 сая төгрөг /	Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо.	139	139	Эхний хагас жилийн байдлаар нийт 28 төрлийн 168 мэдээллийн хугацаанд нь байршуулан ажиллаа.	100

Зорилт 4. Орон нутгийн бусад байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.1	Албан хаагчдын гадаад, дотоодод томилолтоор ажиллах, сургалтад хамруулах асуудлаар гадны болон дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах.	Төсөл, хөтөлбөр	Гадаад болон дотоод сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	4	7	<p>Хэлтсийн дарга, Иргэний бүртгэлийн тасгийн дарга, Нягтлан бодогч УБЕГ-аас зохион байгуулсан танхимийн сургалтанд бүрэн хамрагдсан. Бусад албан хаагчид УБЕГ-аас зохион байгуулсан цахим сургалтанд хамрагдсан байна.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хууль зүйн хэлтэс, Тагнуулийн хэлтэс, Хурлын ажлын алба бусад төрийн байгууллагуудаас зохион байгуулагдсан сургалт семинарт албан хаагчид тухай бүрт идэвхитэй хамрагдаж хууль эрх зүйн мэдлэг мэдээллээ сайжруулж, түүнийгээ ажлын байран дээрээ удирдлага болгон ажиллаж байна.</p> <p>Хэлтсийн зүгээс сургалтын төлөвлөгөө боловсруулан доор сургалтуудыг албан хаагчидаа зохион байгуулж ажилласан байна. 2023.01.03-ний</p>	100
-----	---	-----------------	---	---	---	--	-----

					<p>Хэлтсийн даргын “Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, ХАСХОМ-ын тухай”</p> <p>2023.01.20-ний Архангай аймгийн Татварын хэлтсийн мэргэжилтэн Б.Мөнх-Эрдэнэ ХХОАТ төлөлтийн талаар,</p> <p>2023.01.20-нд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга Д.Отгонбилэг Эд хөрөнгө хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой асуудал арга зүйн зөвлөгөө өгч сургалт зохион байгууллаа. Нягтлан бодогч Г.Солонго хэлтсийн төсвийн талаар 2023.01.26-ний УБЕГ-н чиглэл анхаарах асуудал.</p> <p>2023.02.10-ний Хэлтсийн үнэлгээ, чиглэл анхаарах асуудал хэлтсийн дарга зөвлөгөө өгч сургалт зохион байгуулсан.</p> <p>2023.02.20-ний МТА Л.Санжаажамц биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн зураг засвар программын талаар 2023.03.23-нд Хэлтсийн дарга УБЕГ-с Улсын бүртгэлийн байгууллагын шинэтгэлийн үйл явц талаар</p> <p>2023.04.03 өдөр Хэлтсийн дарга "Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх" аян хүрээнд</p>	
--	--	--	--	--	--	--

						2023.04.12 МТА Л.Санжаажамц Иргэний улсын бүртгэлийн программ шинэчлэгдсэн /түүл/ 2023.05.26 ИУБАБ Ц.Мөнхтамир бүртгэл дээр чиглэл анхаарах асуудал зэргээр тус тус сургалт зохион байгууллаа.	
4.2	Орон нутгийн удирдлага, байгууллагатай хамтран ажиллаж тодорхой асуудлуудыг шийдвэрлүүлсэн байх.	-	-Хамтран ажилласан байгууллагын тоо; -Шийдвэрлэсэн асуудлын тоо	10	12	Аймгийн Засаг даргын тамгын газар болон Сум багийн Засаг дарга нартай нягт хамтран ажиллаж Улсын бүртгэлийн үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүртээмжтэй, чирэгдэл хүнд сурталгүй хүргэх, сумын улсын бүртгэгчийн ажиллах нөхцөл тэдний нийгмийн асуудал ажлын байрны аюулгүй байдал зэрэгт онцгойлон анхаарч асуудлыг байнга хамтран шийдвэрлэж ирсэн. Аймгийн Хууль хяналтын байгууллагуудадтай хамтран ажиллаж мэдээ мэдээллийг харилцан солилцож лавлагаа мэдээллийг цаг тухайд нь хүргэн ажиллаж байна. Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай хамтран хаягийн мэдээлэл болон газрын мэдээллийн санд газрын хэмжээ зөрчилтэй бүртгэгдсэн бүртгэлийг тухай бүр нь арга хэмжээ авч иргэнд чирэгдэлгүйгээр түргэн шуурхай ажиллах талаар албаны уулзалтыг зохион байгуулан Эрдэнэбулган сумын газрын даамалыг хэлтсийн үйлчилгээний зааландаа суулгаж иргэд нэг дороос үйлчилгээ авах бүрэн	100

						<p>боломж нөхцлийг бүрдүүлсэн. 2023.04.0-ний өдрөөс эхлэн Хаан банктай хамтран нийт 29381 иргэнд тоон гарын үсэг олгон ажилласан байна.</p> <p>Шинээр байгуулагдсан Цахим хөгжлийн хэлтэстэй хамтран цахим лавлагаа мэдээллийг цаг алдалгүй гарган өгч байна.</p>	
Зорилт 5. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.							
5.1	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авах.	-	Авсан арга хэмжээний тоо	100	100	<p>Иргэний улсын ахлах бүртгэгч, сумдын 3 улсын бүртгэгч “Орхон” их сургуулийн эрх зүйн эчнээ ангид цахимаар суралцаж байгаа болно.</p> <p>Шинээр томилогдсон бүртгэгчийг шинэ бүртгэгчийн сургалтанд хамруулж, хэлтэс дээр 10 хоног дадлага хийлгэж байж бүртгэл хийлгэж байна.</p>	100
5.2	Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.	-	Хөтөлбөрийн дагуу авсан арга хэмжээ	2	5	<p>Албан хаагчид хамтран Ихтамир сумын нутаг дэвсгэрт 0,5 га газарт төмс хүнсний ногоо тариалан түүний үр шимээр нэг албан хаагч жилийн хэрэгцээний төмс хүнсний ногоогоо хангахаар зорин ажиллаж байна.</p> <p>Эх үрсийн баярыг тохиолдуулан албан хаагч хүүхдүүдэд нийт 999000 төгрөгний үнэ бүхий бэлэг өгч албан хаагчид болон хүүхэд багачуудаа баярлуулаа.</p> <p>Хуулийн этгээдийн Улсын бүртгэгч С.Баттулга Энэтхэг улсруу Тархи мэс</p>	100

						заслийн хагалгаанд ороход албан хаагчдын зүгээс 7200000 төгрөгний мөнгөн дэмжлэг үзүүлсэн бөгөөд С.Баттулга эрүүл саруул болоод Монгол улсдаа эмчлэгдэж байгаа.	
5.3	Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах.	-	Эрүүл мэндийн үзлэгт хамруулсан албан хаагчдын тоо	100	100	Хэлтсийн нийт албан хаагчдыг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр эрүүл мэндийн эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан. Уг үзлэгээр нийт 7 төрлийн шинжилгээ, 9 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, эхо зэрэгт бүрэн оруулсан. Үзлэгт хамрагдсан албан хаагч нарт эмнэлгийн байгууллагаас өгсөн зөвлөмж, зөвлөгөөг сайтар дагаж мөрдөж байна. 2 албан хаагч УБ хотруу нарийн мэргэжлийн шинжилгээнд хамрагдаж онош тодруулсан байгаа. 1 албан хаагч гадаад улсад эмчилгээн явж одоогоо биеийн эрүүл мэнд сайн байгаа.	100

